



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/352

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.15, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөө"-ний 1.1.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мандалговь хот Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуяан хотын хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуяанг хотноо зохион байгуулагдах "Олон улсын цэцэрлэгжүүлэлт-Гуяанг 2019" арга хэмжээнд оролцох төлөөлөгчдийн зардалд шаардагдах 1300000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Замын зардалд шаардагдах 1300000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191001